



VIII/2021

Тархаасан: 2021 оны 9 дүгээр сарын 14




Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 8 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд +38.0⁰ С-д хүрсэн байна

Цаг агаар

Агаарын үнэмлэхүй их температур 2021 оны 8 дугаар сард Баянхонгор аймгийн Шинэжинст суманд +38.0⁰С, үнэмлэхүй бага температур Говь-Алтай аймгийн Тайшир суманд -4.0⁰С-д хүрлээ.

ЗУРАГ 1. АГААРЫН ТЕМПЕРАТУР (°C), олон жилийн дундажтай¹ харьцуулснаар, станцын байршлаар, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар



¹ - 1981-2010 он

Цаг уур, орчны шинжилгээний газрын мэдээгээр 2021 оны 8 дугаар сард орсон хамгийн их хур тунадасны нийлбэр Хөвсгөл аймгийн Шинэ-Идэр суманд 232.3 мм-т хүрсэн байна. Үнэмлэхүй их салхины хурд Дорнод аймгийн Дашбалбар суманд 25 м/с-д хүрсэн байна.

Агаарын чанар

Улаанбаатар хотын агаар дахь хүхэрлэг хийн сарын хамгийн их агууламж 2021 оны 8 дугаар сард бүх станцуудад 0.004 мг/м³ - 0.068 мг/м³-д хүрсэн бөгөөд Амгалан орчимд 0.068 мг/м³ -д хүрч, агаарын чанарын хүлцэх агууламжаас 0.018 мг/м³-аар давсан байна.


Азотын давхар ислийн сарын хамгийн их агууламж 2021 оны 8 дугаар сард бүх станцуудад 0.013 мг/м³– 0.065 мг/м³-д хүрсэн бөгөөд 13-р хороолол, Хархорин зах, Баруун дөрвөн зам орчимд 0.056 мг/м³-0.065 мг/м³ -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас 0.006 мг/м³-0.015 мг/м³- ээр давсан байна.

Харин РМ 10 тоосонцрын сарын хамгийн их агууламж 2021 оны 8 дугаар сард бүх станцуудад 0.064 мг/м³ – 0.278 мг/м³-д хүрсэн бөгөөд Богд хааны ордон музей, 248-р цэцэрлэг, Мишээл экспо төв, Баруун дөрвөн зам, Хайлааст, 1-р хороолол, Ургах наран хороолол, 32-ын тойрог,

Хархорин зах орчимд $0.125 \text{ мг/м}^3 - 0.278 \text{ мг/м}^3$ -д хүрч, агаарын чанарын стандарт хүлцэх агууламжаас $0.025 \text{ мг/м}^3 - 0.178 \text{ мг/м}^3$ -ээр давсан байна.

Улаанбаатар хотын агаар дахь азотын давхар ислийн дундаж агууламж 2021 оны 8 дугаар сард өмнөх оны мөн үеэс 0.001 мг/м^3 (6.2%)-ээр, хүхэрлэг хийн дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.006 мг/м^3 (2.5 дахин)-ээр, PM 2.5 тоосонцорын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.010 мг/м^3 (92.2%)-ээр, PM 10 тоосонцорын дундаж агууламж өмнөх оны мөн үеэс 0.017 мг/м^3 (49.4%)-ээр тус тус их байна.

ЗУРАГ 2. УЛААНБААТАР ХОТЫН АГААР ДАХЬ БОХИРДУУЛАГЧ БОДИСУУДЫН САРЫН ДУНДАЖ АГУУЛАМЖ, жил бүрийн 8 дугаар сарын байдлаар, мг/м^3



Аюулт үзэгдэл, осол

Аюулт үзэгдэл, ослын тохиолдол 2021 оны эхний 8 сард 2621 болж, өмнөх оны мөн үеэс 353 (11.9%)-аар буурсан байна. Объектын түймэр 1684 удаа гарч, өмнөх оны мөн үеэс 542 (24.3%)-оор буурсан байна.

Мөн мал, амьтны халдварт боом өвчний 1, хонины цэцэг өвчний 2, шүлхий 11, галзуу өвчний 19 удаагийн тохиолдол тус тус бүртгэгдсэн байна. Харин шинэ төрлийн Корона вируст (Covid-19) халдварын 206.2 мянган тохиолдол бүртгэгдсэн байна.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 8 сарын байдлаар нийт 1255 хүн амь насаа алдаж өмнөх оны мөн үеэс 1061 (6.5 дахин)-ээр, 205.1 мянган хүн түлэгдэж, бэртэж, өвчилж, хордсон бөгөөд өмнөх оны мөн үеэс 204.8 мянга (574.5 дахин)-аар нэмэгдсэн байна.

2021 оны эхний 8 сарын байдлаар бичил уурхай, нурангийн улмаас 5 хүн, хүчтэй салхи, шуурганы улмаас 11 хүн, объектын түймрийн улмаас 40 хүн, усны ослоор 117 хүн, шинэ төрлийн Корона вируст халдварын улмаас 1049 хүн, бусад золгүй явдлын улмаас 33 хүн амь насаа алджээ.

Аюулт үзэгдэл, ослын улмаас 2021 оны эхний 8 сарын байдлаар 891 гэр, байшин, орон сууц шатаж, өмнөх оны мөн үеэс 193 (17.8%)-аар буурсан байна. Мөн 17.4 тэрбум төгрөгийн хохирол учирч, 2.0 тэрбум төгрөг зарцуулсан байна.

ХҮСНЭГТ 1. АЮУЛТ ҮЗЭГДЭЛ, ОСОЛ, жил бүрийн эхний 8 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I–VIII	2019 I–VIII	2020 I–VIII	2021 I–VIII	$\frac{2021 \text{ I–VIII}}{2020 \text{ I–VIII}}$ %
Аюулт үзэгдэл, ослын тохиолдол	тоо	3 228	3 628	2 974	2 621	88.1
Амь насаа алдсан хүн	тоо	148	162	194	1 255	6.5 ¹
Түлэгдсэн, бэртсэн, өвчилсөн хүн	тоо	47	57	357	205 113	574.5 ¹
Шатсан гэр, орон сууц	тоо	1 158	1 219	1 084	891	82.2
Объектын түймэр	тоо	2 520	3 053	2 226	1684	75.7
Учирсан хохирол	тэрбум төгрөг	16.8	31.3	108.2	17.4	16.1
Зарцуулсан зардал	сая төгрөг	9 996.9	1 060.7	255.7	1 985.5	7.8 ¹

¹ - Дахин их

Аюулт үзэгдэл, ослоос 2021 оны эхний 8 сарын байдлаар 2755 хүнийг аварч, 71.7 тэрбум төгрөгийн эд хөрөнгийг хамгаалсан байна.

Ойлголт, тодорхойлолт

Агаарын бохирдол:

Агаар мандалд нэг буюу хэд хэдэн химийн бодис дагнасан буюу хавсарсан байдлаар хүн, амьтан, ургамлын аймгийн амьдрал, ахуйн нөхцөл, үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл үзүүлж, стандартаар тогтоосон хүлцэх хэм хэмжээнээс давсан агаар дахь бохирдуулах бодис тодорхой хугацаагаар байхыг ойлгоно.

Аюулт үзэгдэл: Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт болох, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин гарах, хортон мэрэгчид тархах зэргийг ойлгоно.

Гамшиг: Аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, алан хядах ажиллагаа, дэлбэрэлтийн улмаас олон хүний эрүүл мэнд, амь нас хохирох, мал, амьтан олноор хорогдох, эд хөрөнгө, хүрээлэн байгаа орчинд улс, орон нутгийн дотоод нөөц боломжоос давсан хохирол учрахыг ойлгоно.

Зөвшөөрөгдөх түвшин: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь физикийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх түвшинг ойлгоно.

Хүлцэх агууламж: Хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх агаар дахь химийн бохирдуулагчийн зөвшөөрөгдөх хэмжээг ойлгоно.



Эх үүсвэр: Цаг уур, орчны шинжилгээний газар, Онцгой байдлын ерөнхий газар

Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн
газрын дарга А.Дэмбэрэл
Утас : (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн
газрын ахлах статистикч Б.Уянгаа
Утас : (976-51)-261563

